

ХОТОД ШИЛЖИН ИРЭГСДИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Т.Навч ахлах багш/судлаач,
Д.Хүрэлмаа багш/судлаач,
МУИС, Эдийн Засгийн Сургууль,
Хүн Амын Сургалт Судалгааны Төв

Монголд хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал үргэлжилсээр байна. Энэ нь хот төлөвлөлт, хотын менежментийн асуудлыг хундрүүлээд зогсохгүй хотын хүн амын ядууралд нэрмээс болсоор байна.

Энэхүү судалгаанд шилжин ирэгсэд болон шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амын амьдрал, ахуйн нөхцлийн ялгаатай байдал, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хуртээмж, эдийн засгийн байдал, шилжигч хүн амд тохиолдож буй хундрэл бэрхшээлүүдийг тодруулж, үйл ажиллагааны нэн тэргүүний зорилтомт бүлгийг тодорхойлохыг зорьсон юм.

Судалгаанд шилжигч хүн амыг шилжигч бус хүнтай харьцуулан орлого хэрэглээний ядуурал болон нийгмийн эмзэг бүлэгт багтах магадлалыг олон хучин зүйлсийн регрессийн аргаар тодорхойлж гаргав.

Хотод шилжин ирэгчид голдуу дэд бүтэц муу хөгжсөн, нийгмийн үйлчилгээний чанар төдийгүй хуртээмж муутай хотын захын гэр хорооллуудад аж төрж байна. Бүртгэл нь хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулахад нөлөөлж чадахгүй байна. Шилжигчид шилжигч бус хүн амаас илүү ядуу амьдарч байна. Тэд хотод шилжин ирсэн учраас ядуу амьдарч байгаа бус харин боловсрол багатай, чадавхи сүл байгаагаас ядуурал, нийгмийн эмзэг байдалд илүү өртөмтгийг байна.

Шилжих хөдөлгөөнийг бууруулахын тулд орон нутагт хүн амын эдийн засгийн болон боловсролын байдлыг сайжруулах асуудал хамгийн чухал байна.

Оршил

Монголд сүүлийн жилүүдэд хөдөөгөөс хот руу, ялангуяа Улаанбаатар хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал үргэлжилсээр байна. Хүн ам, орон сууцны 2000 оны тоологоос (ҮСГ, 2001) үзэхэд Улаанбаатар хотын хүн амын гуравны нэгийг шилжин ирэгсэд бүрдүүлж байна.

Шилжих хөдөлгөөний үр дагавар Улаанбаатар хотын гэр хороололд илүү тод илэрч байна. Хотын гэр хорооллын хүн амын хурдтай өсөлт нь хотын нийгэм, эдийн засгийн болон засаг захиргааны ажилд асар их ачаалал үүсгэж, ядуурлыг улам бүр гүнзгийрүүлэн тэлж байна. Гэр хорооллын оршин суугчдын олонхи нь ажилгүй эсвэл албан бус секторт ажиллах нэр төдий аж төрж байна. Шилжин ирэгсдийн энэхүү түрэлт дэд бүтцийн чадавхийг шавхаж байгаа бөгөөд хөдөөнөөс ирээд дасан зохицох, амьжиргааны наад захын нөхцлийг бүрдүүлэхэд нь туслах, боловсрол, эмнэлгийн үйлчилгээнд хамруулах зэрэг нийгэм, эдийн

засгийн олон асуудлыг шийдвэрлэхэд сайтар боловсруулсан төлөвлөгөө, зохион байгуулалтын ажил шаардагдаж байна.

2000 онд хийгдсэн Монголын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаагаар шилжин ирэгчдийн ахуйн нөхцөл Улаанбаатар хотын шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амтай харьцуулахад муу байна гэсэн дүн гарчээ (НХХЯ, ХАССТ, НҮБХАС, 2001).

Шилжих хөдөлгөөн нь ядууралд нөлөө үзүүлсээр байна. Ядуучуудын бодит тоо 1995 онд 828 мянга байснаа 1998 онд 849.8 мянга болж өссөн боловч нийт хүн амд ядуу хүн амын эзлэх хувийн жин 36.3-аас 35.6 хувь болж буурчээ. Нийт ядуучуудын талаас илүү хувь нь хот, суурин газарт, тэдгээрийн дөрөвний нэг орчим хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байна. Ядуу хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг илэрхийлэгч үзүүлэлт болох ядуурлын ялгаа 1995 онд 5.7 байснаа 7.1 болж өсчээ (Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, 2000).

Цэвэр усаар хангагдаж чадаагүй айл өрхүүд олон байгаагийн зэрэгцээ тэд хог, хаягдал, муу ус, бохир зайлцуулах нэгдсэн сүлжээгүй орчинд, ердийн зуухан халаалттай, халуун усны гачаалалтай аж төрж байна. Гэр хороололд цахилгаанд холбогдоогүй өрхүүд ч цөөнгүй байна.


Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яамны захиалга, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр МУИС-ийн ЭЗС-ийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төв 2004 онд Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн түүвэр судалгааг хийж дуусгалаа. Судалгаанд Улаанбаатар хотын 1500 өрхийн 6847 хүн ам хамрагдсан юм.

Судалгаанд Улаанбаатар хотод сүүлийн 4 жилд шилжин ирсэн 15-64 насны хүнтэй болон энэ насны өрхийн тэргүүлэгч нь шилжих хөдөлгөөнд оролцсон өрхүүдийн шилжих хөдөлгөөний талаарх мэдээллийг харьцуулан дүгнэсэн бөгөөд үр дүнт түхэнд танилцуульяа.

1. Шилжигчдийн шинж байдал

Судалгаанд нийт 1500 өрхийн 6847 хүн ам хамрагдсаны 4024 нь 15-64 насны хүн ам байсан бөгөөд тэдгээрийн 14.6 хувь (нийт өрхийн 13.4 хувь) нь судалгаанаас өмнөх 4 жилийн хугацаанд хотод шилжиж ирсэн хүн ам байлаа. Нийт өрхийн 11.7 хувь нь шилжин ирсэн өрх, 17.8 хувь нь шилжин ирсэн хүнтэй өрх байв. Шилжих хөдөлгөөнд оролцсон хүмүүсийн 79.5 хувь нь гэр хороололд, 20.5 хувь нь байшин хороололд амьдрагч байна. Шилжин ирэгсэд (цаашид өөрөө өөрөөдөр гэж нэрлэнэ) болон шилжих хөдөлгөөнд оролцоогүй (цаашид өөрөө өөрөөдөр гэж нэрлэнэ) хүн амын нас, хүйсийн бүтцийг Зураг 1-д харуулав.

*Зураг 1. Хүн амын нас, хүйсийн суварга
Шилжигч ба шилжигч бус*



Хүснэгт 1-д шилжигч болон шилжигч бус хүн амын шинж байдлыг байршилаар харуулав. Шилжигч, шилжигч бус хүн амын аль алинд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин эрэгтэйчүүдийнхээс илүү байна.

Шилжигчдийн талаас илүү буюу 58.7 хувийг 15-29 насны залуучууд эзэлж байна. Энэ үзүүлэлтийг шилжигч бус хүн амтай харьцуулахад 10 пунктээр өндөр хэдий ч байршилын хувьд онцын ялгаагүй байна. Харин байшин хорооллын шилжигч бус хүн амд 15-29 насны залуучуудын эзлэх хувийн жин шилжигч бус залуучуудаас 14.6, гэр хорооллын шилжигч бус мөн насны залуучуудаас 6.2, шилжигч залуучуудаас 13.5 пунктээр тус тус доогуур байна. Өөрөөр хэлбэл, байшин хороололд нас тогтсон хүмүүсийн эзлэх хувь, гэр хороололд залуучуудын эзлэх хувь өндөр байна.

Гэрлэлтийн байдлаар үзвэл, огт гэрлээгүй шилжигч хүн ам гэр хороололд 45.9 хувь, байшин хороололд 49.6 хувийг тус тус эзэлж байна. Харин байшин хороололд шилжигч бус ганц бие хүн амын эзлэх хувь (37.1 хувь) шилжигч ганц бие хүн амтай харьцуулахад 12.5 пунктээр өндөр байв. Энэ нь дээр дурьдсанчлан байшин хороололд харьцангуй удаан хугацаагаар хотод суурьшсан, нас тогтсон, гэр бүлтэй, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүмүүс голдуу амьдардаг болохыг харуулж байна. Түүнчлэн бэлбэсэн хүмүүсийн эзлэх хувийн жин байшин хороололд өндөр байгааг Хүснэгт 1-ээс харж болно.

Улаанбаатар хотод шилжин ирэгчдийн 81.2 хувийг халх, 4.2 хувийг баяд, 2.8 хувийг дөрвөд, 2.3 хувийг буриад, 1.7 хувийг казакууд эзэлж байна.

Очигдэх 1. 15-64 насны хүн амын хувийн жин, байршил, шилжилтийн байдал, хүн ам зүйн шинж байдлаар

| Хүн ам зүйн үзүүлэлтүүд | Гэр хороолол | | Байшин хороолол | | Нийт | |
|--------------------------|----------------|----------------|-----------------|----------------|----------------|----------------|
| | Шилжигч бус | Шилжигч бус | Шилжигч бус | Шилжигч бус | Шилжигч бус | Шилжигч бус |
| Хүйс | | | | | | |
| Эрэгтэй | 46.3 | 46.2 | 45.4 | 45.5 | 46.1 | 45.9 |
| Эмэгтэй | 53.7 | 53.8 | 54.6 | 54.5 | 53.9 | 54.1 |
| Хүйсийн харьцаа | 86.2 | 85.9 | 83.2 | 83.5 | 85.5 | 84.8 |
| Насны бүлэг | | | | | | |
| 15-19 | 20.8 | 21.0 | 21.3 | 17.2 | 20.9 | 19.3 |
| 20-24 | 21.8 | 16.1 | 24.8 | 14.5 | 22.4 | 15.4 |
| 25-29 | 16.1 | 14.3 | 12.8 | 13.5 | 15.4 | 14.0 |
| 30-34 | 11.0 | 9.9 | 11.3 | 10.7 | 11.0 | 10.3 |
| 35-39 | 7.7 | 9.4 | 5.7 | 10.3 | 7.3 | 9.8 |
| 40-44 | 8.0 | 9.3 | 9.2 | 11.4 | 8.3 | 10.3 |
| 45-49 | 5.7 | 7.1 | 5.7 | 8.1 | 5.7 | 7.6 |
| 50-54 | 4.2 | 6.1 | 5.0 | 6.9 | 4.4 | 6.5 |
| 55-59 | 2.0 | 2.8 | 1.4 | 4.0 | 1.9 | 3.4 |
| 60-64 | 2.7 | 3.8 | 2.8 | 3.4 | 2.8 | 3.6 |
| Гэрэлтийн байдал | | | | | | |
| Огт гэрлээгүй | 45.9 | 41.4 | 49.6 | 37.1 | 46.7 | 39.4 |
| Баталгаатай гэр бүл | 38.2 | 38.3 | 33.3 | 43.8 | 37.2 | 40.8 |
| Баталгаагүй гэр бүл | 11.3 | 10.9 | 9.2 | 9.2 | 10.9 | 10.1 |
| Тусгаарласан | 0.9 | 2.0 | 2.1 | 1.6 | 1.2 | 1.8 |
| Салсан | 0.4 | 2.3 | 2.1 | 3.4 | 0.7 | 2.8 |
| Бэлбэсэн | 3.3 | 5.1 | 3.5 | 5.0 | 3.3 | 5.0 |
| Яс үндэс | | | | | | |
| Халх | 81.2 | 88.9 | 80.9 | 91.1 | 81.1 | 89.9 |
| Казак | 0.5 | 4.3 | 6.4 | 0.2 | 1.7 | 2.5 |
| Дөрвөд | 2.9 | 2.2 | 2.1 | 1.9 | 2.8 | 2.1 |
| Буриад | 1.8 | 0.6 | 4.3 | 2.3 | 2.3 | 1.4 |
| Баяад | 4.8 | 1.8 | 2.1 | 2.0 | 4.2 | 1.9 |
| Бусад* | 8.8 | 2.2 | 4.3 | 2.5 | 7.8 | 2.3 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15-64 насны хүн амын тоо | 547 | 2213 | 141 | 1811 | 688 | 4024 |

*Öгт яялжсан: * - Гадаадын 9 хүнийг бусад гэсэн ангилалд оруулав.*

2. Өрхийн шинж байдал, ахуйн нөхцөл

Судалгаагаар тухайн өрхийн тэргүүн шилжих хөдөлгөөнд оролцсон тохиолдолд өрхийг шилжигч өрх гэж авч үзэв. Судалгаанд хамрагдсан өрхийн шинж байдлыг байршил болон шилжилтийн байдлаар Хүснэгт 2-д харуулав.

Өрхөд амьдардаг хүний тоогоор авч үзэхэд 3-4 хүнтэй шилжигч болон шилжигч бус өрхүүд хамгийн өндөр, ойроцоогоор нэг өрхөд 4.3 хүн ногдож байна. Харин 5 ба түүнээс дээш хүн амьдардаг шилжигч өрхийн хувийн жин ийм хүн амтай шилжигч бус өрхөөс өндөр байна. Энд нэг сонирхол татсан үзүүлэлт бол нэг өрхөд амьдардаг гэр бүлийн тоо өрхийн байршилаар нэлээд ялгаатай байна. Тухайлбал, байшин хороололд шилжигч бус гэхдээ нэгээс олон ам бүл нэг байр/сууцанд амьдрах явдал илүү байдаг нь судалгаагаар харагдлаа. Үүнийг шинээр гэр бүл болсон залуучууд байшин хороололд амьдрах сонирхолтой байдгаас эцэг, эхтэйгээ хамт амьдардаг, нөгөө талаас сүүлийн жилүүдэд байшин хороололд хүмүүс хажуу өрөө олонтой хөлсөлдөг болсонтой холbon тайлбарлаж болох юм. Мөн өрхөд амьдарч буй хүүхдийн тоо гэр хороололд байшин хорооллынхоос хоёр дахин өндөр байна.

Хүснэгт 2. 15-64 насны тэргүүнтэй өрхийн хувийн жин, байршил, шилжилтийн байдал, өрхийн шинж байдлаар

| Өрхийн шинж байдал | Гэр хороолол | | Байшин хороолол | | Нийт | |
|-----------------------------------|--------------|-------------|-----------------|-------------|---------|-------------|
| | Шилжигч | Шилжигч бус | Шилжигч | Шилжигч бус | Шилжигч | Шилжигч бус |
| Өрхөд амьдарч буй хүний тоо | | | | | | |
| 1-2 | 7.5 | 5.5 | 28.6 | 13.5 | 12.5 | 9.3 |
| 3-4 | 31.3 | 40.8 | 50.0 | 54.0 | 35.8 | 47.1 |
| 5-6 | 41.0 | 35.2 | 16.7 | 23.7 | 35.2 | 29.8 |
| 7 ба түүнээс олон | 20.1 | 18.5 | 4.8 | 8.7 | 16.5 | 13.9 |
| Дундаж | 5.14 | 5.06 | 3.52 | 4.17 | 4.76 | 4.64 |
| Ам бүлийн дундаж тоо | 4.59 | 4.77 | 3.33 | 3.86 | 4.29 | 4.34 |
| Өрхөд шилжин ирсэн хүний тоо | | | | | | |
| 0 | - | 91.7 | - | 95.7 | - | 93.6 |
| 1-2 | 38.8 | 6.8 | 54.8 | 4.3 | 42.6 | 5.6 |
| 3-4 | 43.3 | 1.2 | 40.5 | - | 42.6 | 0.6 |
| 5 ба түүнээс олон | 17.9 | 0.3 | 4.8 | - | 14.8 | 0.2 |
| Дундаж | 3.23 | 0.14 | 2.52 | 0.05 | 3.06 | 0.10 |
| Өрхөд амьдарч буй гэр бүлийн тоо | | | | | | |
| 1 | 85.1 | 82.5 | 95.2 | 86.5 | 87.5 | 84.4 |
| 2 ба түүнээс олон | 14.9 | 17.5 | 4.8 | 13.5 | 12.5 | 15.6 |
| Хүүхдийн дундаж тоо | 2.27 | 2.46 | 1.17 | 1.76 | 2.01 | 2.13 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15-64 насны тэргүүнтэй өрхийн тоо | 134 | 600 | 42 | 539 | 176 | 1139 |

Судалгаанд хамрагдсан өрхийн сууцны төрлийг шилжих хөдөлгөөний байдлаар Хүснэгт 3-д задлан харуулав.

Хүснэгт 3. 15-64 насны тэргүүнтэй өрхийн хувийн жин, шилжилтийн байдал, өрхийн сууцны үзүүлэлтүүдээр

| Сууцны үзүүлэлтүүд | Шилжилтийн | | |
|---|------------|-------------|-------|
| | байдал | Нийт | |
| | Шилжигч | Шилжигч бус | |
| Өрхийн сууцны төрөл | | | |
| Байшин* | 48.3 | 87.4 | 82.2 |
| Гэр | 51.7 | 12.6 | 17.8 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15-64 насны тэргүүлэгчтэй нийт өрхийн тоо | 176 | 1139 | 1315 |
| Сууцны зориулалт** | | | |
| Сууцны тусдаа байшин | 45.9 | 43.7 | 43.8 |
| Нийтийн сууцны байшин доторх сууц | 36.5 | 50.2 | 49.1 |
| Нийтийн эзэмшилийн байр | 5.9 | 3.9 | 4.1 |
| Сууцны бус | 11.8 | 2.2 | 3.0 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15-64 насны тэргүүлэгчтэй, байшинд амьдардаг өрхийн тоо | 85 | 996 | 1081 |
| Сууцны эзэмшил** | | | |
| Өөрийн эзэмшилийн | 77.1 | 88.5 | 87.0 |
| Өөрийн эзэмшилийн бус | 22.9 | 11.5 | 13.0 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| Тоо | 166 | 1117 | 1283 |

Тэмдэглэгээ: * Уүнд: Сууцны тусдаа байшин, нийтийн сууцны байшин доторх сууц, нийтийн эзэмшилийн байрууд мөн сууцны зориулалтын бус байрууд орно.

** Гэр ороогүй

*** Сууцны бус болон бусад гэсэн ангилал ороогүй

Шилжигч өрхийн 48.3 хувь нь байшинд (гэр хорооллын байшин орсон), 51.7 хувь нь гэрт амьдарч байна. Гэрт амьдарч буй шилжигч бус өрхийн (87.4 хувь) эзлэх хувийн жин шилжигч өрхийнхөөс (12.6 хувь) бараг 4 дахин бага байна. Хөдөө, орон нутгаас шилжин ирэгсдийн багагүй хувь нь хүн амьдрах зориулалтаар баригдаагүй тав тух муутай орчинд амьдардаг болохыг судалгааны дүн харуулж байна. Тухайлбал, сууцны төрлөөр үзэхэд сууцны тусдаа байшинд шилжигч өрхийн 36.5 хувь, шилжигч бус өрхийн 50.2 хувь нь амьдарч байхад сууцны бус байранд (гэр орохгүй) шилжигч өрхийн 11.8 хувь, шилжигч бус өрхийн ердөө 2.2 хувь нь амьдарч байлаа.

Гэрт амьдарч буй хүн амын сууцны ахуй нөхцөл шилжигч болон шилжигч бус өрхүүдийн хувьд тун ойролцоо байна. Тухайлбал, гэрт амьдарч буй нийт өрхүүдийн талаас илүү (65) хувь нь 5 ханатай гэрт амьдардаг ба шилжилтийн байдлаар онцын ялгаа байхгүй байна. Өвлийн хүйтэнд шилжигч өрхийн 47.3 хувь нь дан бүрээстэй, 46.2 хувь нь дан туургатай, 29.7 хувь нь шалгүй хүнд нөхцөлд амьдардгийг судалгааны дүн харууллаа. Ер нь гэрт амьдарч буй шилжигч өрх төдийгүй шилжигч бус өрхийн цөөнгүй хэсэг дан бүрээс, дан туургатай, шалгүй гэрт хүнд нөхцөлд амьдарч байна.

Хүснэгт 4. 15-64 насны тэргүүнтэй, гэрт амьдардаг өрхүүдийн хувийн жин, шилжилтийн байдал, сууцны нөхцлөөр

| Сууцны нөхцөл | Шилжилтийн байдал | | Нийт |
|---|-------------------|-------------|-------|
| | Шилжигч | Шилжигч бус | |
| Ханын тоо | | | |
| <4 | 19.8 | 23.1 | 21.8 |
| 5 | 62.6 | 66.4 | 65.0 |
| 6 ба түүнээс дээш | 17.6 | 10.5 | 13.2 |
| Туурга | | | |
| Дан | 47.3 | 37.8 | 41.5 |
| Давхар | 52.7 | 62.2 | 58.5 |
| Бүрээс | | | |
| Дан | 46.2 | 39.2 | 41.9 |
| Давхар | 53.8 | 60.8 | 58.1 |
| Шал | | | |
| Шалтай | 70.3 | 80.4 | 76.5 |
| Шалгүй | 29.7 | 19.6 | 23.5 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15-64 насны өрхийн тэргүүнтэй, гэрт амьдардаг нийт өрхийн тоо | 91 | 143 | 234 |

Шилжигч өрхийн 8.5 хувь, шилжигч бус өрхийн 2.0 хувь нь дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн нийслэл хотод амьдарч байгаа хэдий ч төвлөрсөн сүлжээгээр цахилгаан хэрэглэж чадахгүй байна (Хүснэгт 5). Энэ бол дэд бүтэцтэй холбогдоогүй, манайхны ярьдгаар *չաճաճաéá* шилжин суурьшигч өрхүүдийн цөөнгүй хэсэг нь гэр хороололд байгаатай холбоотой юм. Мөн төвлөрсөн халуун ба хүйтэн ус хэрэглэх боломжоор хангагдаагүй шилжигч өрхийн эзлэх хувийн жин шилжигч бус өрхөөс 2 дахин өндөр байна.

Техник технологийн хурдацтай хөгжлийн өнөөгийн нөхцөлд хүний наад захын хэрэгцээ болсон утсан харилцаанд шилжигч өрхүүдийн тал хүрэхгүй хувь, шилжигч бус өрхүүдийн 64.5 хувь нь холбогдсон байна.

Хүснэгт 5. 15-64 насны тэргүүнтэй, гэрт амьдардаг өрхүүдийн хувийн жин, шилжилтийн байдал, ахуйн нөхцлөөр

| Ахуйн нөхцөл | Шилжилтийн байдал | | Нийт |
|---------------------------------------|-------------------|-------------|-------|
| | Шилжигч | Шилжигч бус | |
| Гэрэлтүүлэг | | | |
| Төвлөрсөн цахилгаан | 91.5 | 98.0 | 97.1 |
| Лаа | 8.5 | 2.0 | 2.9 |
| Үндны усны эх үүсвэр | | | |
| Төвлөрсөн: Халуун, хүйтэн устай | 20.5 | 44.4 | 41.2 |
| Зөвхөн хүйтэн устай | 2.3 | 1.5 | 1.6 |
| Худаг | 72.2 | 53.9 | 56.3 |
| Бусад | 5.0 | 0.2 | 0.8 |
| Халаалт | | | |
| Төвлөрсөн | 23.3 | 46.3 | 43.2 |
| Төвлөрсөн бус | 1.1 | 2.0 | 1.9 |
| Ердийн | 75.6 | 51.7 | 54.9 |
| Хог зайлцуулалт | | | |
| Тусгай зориулалтын хогийн цэгт | 84.1 | 96.3 | 94.7 |
| Ил задгай нүх, суваг, шуудуунд | 15.9 | 3.7 | 5.3 |
| Хэрэглэдэг түүшний төрөл* | | | |
| Цахилгаан | 41.5 | 62.8 | 59.9 |
| Мод | 71.6 | 52.9 | 55.4 |
| Нүүрс | 69.9 | 50.7 | 53.2 |
| Бусад | 4.5 | 2.9 | 3.1 |
| Бие засах газар | | | |
| Сууц дотроо төвлөрсөн: Тусдаа | 17.6 | 44.3 | 40.8 |
| Нийтийн | 6.8 | 2.1 | 2.7 |
| Нүхэн жорлон | 70.5 | 52.5 | 54.9 |
| Ил задгай | 5.1 | 1.1 | 1.6 |
| Утастай эсэх** | | | |
| Утастай | 45.5 | 64.5 | 62.0 |
| Утасгүй | 54.5 | 35.5 | 38.0 |
| Илүү гэр/байшин/гарааштай эсэх | | | |
| Байгаа | 19.3 | 36.2 | 34.0 |
| Байхгүй | 80.7 | 63.8 | 66.0 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15-64 насны өрхийн тэргүүнтэй, гэрт | | | |
| Амьдардаг нийт өрхийн тоо | 91 | 143 | 234 |

Тэмдэглэл: * Гэр ороогүй.

** Олон сонголттой хариулгаас тооцсон хувь.

Судалгаанд хамрагдагчдаас тухайн өрхдөө бүртгэлтэй эсэхийг асуусан бөгөөд үр дүнг байршил болон шилжилтийн байдлаар *Хүснэгт 6-д* харууллаа.

Хүснэгт 6. 15-64 насны хүн амын хувийн жин, тухайн өрхөд бүртгэлтэй эсэх, байршил, шилжилтийн байдлаар

| Өрхдөө бүртгэлтэй эсэх | Гэр хороолол | | Байшин хороолол | |
|-------------------------------|--------------|-------------|-----------------|-------------|
| | Шилжигч | Шилжигч бус | Шилжигч | Шилжигч бус |
| Бүртгэлтэй | 80.6 | 95.2 | 80.1 | 93.6 |
| Бүртгэлгүй | 19.4 | 4.8 | 19.9 | 6.4 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 15-64 насны нийт хүн амын тоо | 547 | 2213 | 141 | 1811 |

Тухайн өрхөд бүртгэлтэй хүн амын эзлэх хувийн жин байршилын хувьд онцын ялгаагүй байна. Харин шилжигч, шилжигч бус өрхийн хувьд нэлээд ялгаа ажиглагдаж байна. Тухайлбал, гэр хорооллын шилжигч өрхөд амьдарч буй бүртгэлгүй хүн амын хувийн жин (19.4 хувь), шилжигч бус өрхөд амьдарч буй бүртгэлгүй хүн амынхаас 4 дахин, харин байшин хорооллын шилжигч өрхөд амьдарч буй бүртгэлгүй хүн амын хувийн жин (19.9 хувь) шилжигч бус өрхөд амьдарч буй хүн амынхаас 3 дахин өндөр байв.

3. Шилжигчдийн боловсрол

Судалгаанд хамрагдсан хүн амын боловсролын түвшинг шилжилтийн байдал, байршилаар Хүснэгт 7-д харуулав.

Шилжигч бус хүн амын боловсролын түвшин срөнхийдөө дээгүүр байна. Тухайлбал, шилжигчдийн 38.7 хувь нь бүрэн бус дундаас доош боловсролтой болон боловсролгүй хүмүүс байхад шилжигч бус хүн амын хувьд энэ үзүүлэлт 30.6 хувь буюу 8.1 пунктээр доогуур байна. Харин дээд боловсролтой шилжигч бус хүн амын хувийн жин шилжигч хүн амынхаас 11.0 пунктээр өндөр байна. Энэ нь шилжигчдийн шилжих хөдөлгөөнд оролцох томоохон шалтгааны нэг нь суралцах, өөрөөр хэлбэл, мэргэжил, боловсрол эзэмших явдалтай холбоотой юм.

Хөдөө орон нутгаас шилжин ирэгчдийн дунд боловсролгүй хүмүүсийн эзлэх хувь нийслэлд амьдардаг хүмүүсийнхээс нэлээд дээгүүр байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн байшин хороололд амьдардаг шилжигч хүн амын 32.6 хувь нь дээд боловсролтой, гэр хорооллын шилжигч хүн амын дөнгөж 6.8 хувь нь дээд боловсролтой хүмүүс байв. Шилжигчдийн боловсролын түвшин нэмэгдэх тутам байшин хороололд амьдарч буй шилжигчдийн хувийн жин нэмэгдэж байна. Эндээс боловсрол өндөртэй хүн ам голдуу байшин хороололд амьдарч байна гэж хэлж болохоор байна.

Хүснэгт. 7. 15-64 насны хүн амын хувийн жин, байршил, шилжилтийн байдал, сонгосон үзүүлэлтүүдээр

| Сонгосон үзүүлэлтүүд | Гэр хороолол | | Байшин хороолол | | Нийт | |
|--|--------------|-------------|-----------------|-------------|---------|-------------|
| | Шилжигч | Шилжигч бус | Шилжигч | Шилжигч бус | Шилжигч | Шилжигч бус |
| Боловсролын түвшин | | | | | | |
| Боловсролгүй | 3.1 | 1.9 | 2.8 | 0.8 | 3.1 | 1.4 |
| Бага | 11.7 | 9.9 | 6.4 | 4.5 | 10.6 | 7.5 |
| Бүрэн бус дунд | 27.8 | 28.8 | 14.2 | 13.5 | 25.0 | 21.8 |
| Бүрэн дунд | 38.6 | 35.9 | 35.5 | 31.7 | 37.9 | 34.0 |
| Техник мэргэжлийн | 5.1 | 5.2 | 2.8 | 2.8 | 4.7 | 4.1 |
| ТМД, бүрэн бус дээд | 6.9 | 7.3 | 5.7 | 8.9 | 6.7 | 8.0 |
| Дээд | 6.8 | 11.0 | 32.6 | 37.9 | 12.1 | 23.1 |
| Ажил эрхлэлтийн байдал | | | | | | |
| Ажил эрхэлдэг | 39.9 | 42.1 | 43.3 | 52.3 | 40.6 | 46.7 |
| Ажил эрхэлдэггүй | 60.1 | 57.9 | 56.7 | 47.7 | 59.4 | 53.3 |
| Бүгд 15-64 насны нийт хүн амын тоо | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| | 547 | 2213 | 141 | 1811 | 688 | 4024 |

Сургууль завсардалт

Чанарын судалгааны дүнгээс харахад шилжигч өрхийн хүүхдүүдийн боловсрол эзэмших боломж шилжигч бус өрхийн хүүхдүүдээс хавыгүй доогуур байгаа нь харагдаж байна.

*“Шилжисиж ирээд хүүхдээ сургуульд оруулах бол хамгийн хэцүү асуудал.
Багтахгүй ачаалал ихтэй байна гээд ер халгаадаггүй. Тэгээд таньдаг хүнээ
гүйж байгаад гэрээсээ хол, харьяаллын бус сургуульд хүүхдээ оруулсан”*
(Ц.эмэгтэй, нас 39, шилжин ирсэн бүртгэлгүй, СХД)

Сургууль завсардалтын томоохон шалтгааны нэг нь шилжих хөдөлгөөн гэж өмнө хийгдэж байсан судалгаануудад өгүүлсэн хэдий ч байршилын ялгааг орхигдуулсан юм. Иймд бид судалгаандaa сургууль завсардалтыг шилжих хөдөлгөөн болон байршилын ялгавартай байдлаар авч үзсэн. Гэр хорооллын хүүхдүүдийн дунд сургууль завсардалт харьцангуй өндөр байгаа боловч шилжилтийн байдлаар ялгаа харьцангуй бага байна. Тухайлбал, байшин хорооллынхонтой харьцуулахад гэр хорооллын сургууль завсардсан хүүхдийн тоо бараг 8 дахин өндөр байв. Харин сургууль завсардсан хүүхдүүдийн талаас илүү хувийг гэр хорооллын шилжигч бус өрхийн хүүхдүүд эзэлж байна. Сургууль завсардсан гэр хорооллын шилжигч өрхийн хүүхдүүдийн талаас илүү нь эрэгтэй хүүхдүүд байна.

Бүртгэлгүй гэсэн шалтгаанаар гэр хорооллын шилжигч өрхийн хүүхдийн 33,3 хувь нь сургууль завсардсан байхад байшин хороололд ийм шалтгаан гараагүй. Гэр хорооллын шилжигч өрхийн хүүхдийн тал орчим нь 5-8 дугаар ангиас завсардаж байгаа нь ихээхэн анхаарал татаж байна.

Албан бус сургалтад сургууль завсардсан шилжигч өрхийн хүүхдүүд бараг хамрагдаагүй (4 хүүхэд л хамрагдсан) байна.

4. Шилжигчдийн эрүүл мэнд

Шилжигчдэд эмнэлгийн үйлчилгээнээс хүртэх боломж тааруу болох нь чанарын судалгааны дүнгээс харагдлаа. Үүнийг тэд нэг талаар эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах боломжоо мэддэггүй, мэдээлэл муутай байдаг, нөгөө талаар хотын захын гэр хороололд эмнэлгийн үйлчилгээ тийм ч сайнгүй байдагтай холбон ярьж байв. Учир нь шилжин ирсэн, тухайн хороонд бүртгэлгүй иргэдэд эмнэлгийн наад захын үзлэг, оношлогоо хийдэггүй бөгөөд харин өвчилсөн эсвэл өвчин хүндэрсэн тохиолдолд эмнэлгийн үйлчилгээнд хамруулдаг ажээ.

*“Манай өрхийн эмнэлэг их хол. Ер нь эмч нар их зантай, их ааш муутай.
Өдөржин олон хүн үзээд уур нь хурчихдэг юм байлгүй. Шилжисиж ирсэн бид
нарыг байтугай үндсэн иргэдээ үзээж дийлдэггүй юм билээ”*
(Ч. эмэгтэй, нас 61, тэтгэвэрт, шилжин ирсэн бүртгэлгүй, СХД)

Тэгэхдээ үүнийг дан ганц захын хорооллын эмнэлгийн үйлчилгээ, чанартай холбон тайлбарлаж болохгүй юм. Тэнд эмнэлгийн орчин, нөхцөл тийм ч сайн биш байдаг тухай эмнэлгийн эмч, ажилтнууд шүүмжилж байлаа.

“Ажиллах нөхцөл үнэхээр муу. Энэ байранд ороод 2 жил ч болоогүй байж бороо орохоор тааз нь төмбийгөөд дусаал гоождог. Тарианы өрөө гэхэд усгүй, өвчтөнгүүдийн гадуур хувцсыг өлгөх тусдаа өрөө ч байдаггүй. Өрхийн эмнэлгийн хувьд усны хангамжийг сайжруулах, мөн төвийн халаалттай холбоож өгвөл ажлын нөхцөл маань арай сайжрах байх”

(И, эмэгтэй, нас 50, өрхийн эмч, СХД)

Хүн амын эрүүл мэндийг байршил болон шилжилтийн байдлаар Хүснэгт 8-д харуулав.

Шилжигчдийн 13.9 хувь нь өөрийгөө эрүүл мэндийн хувьд муу, архаг хууч өвчтэй гэж хариулсан байхад шилжигч бус хүн амын 17.2 хувь нь дээрх хариултыг өгчээ. Шилжигч, шилжигч бус хүмүүсийн ийм хариултын хувь байшин хорооллын хувьд 7.7 пунктээр зөрүүтэй байна. Шилжигчдийн эрүүл мэнд шилжигч бус хүн амынхаас арай дээр байна. Энэ нь нэг талаар шилжих хөдөлгөөнд эрүүл хүмүүс орох магадлал өндөр, нөгөө талаар шилжигчид угуул нутагтаа эрүүл мэндийн нарийн үзлэгт хамрагдах боломж муу, улмаар өөрсдийн эрүүл мэндийн талаар мэдлэг дутмаг байж болох талтай.

Өгүүлэх 8. 15-64 насын хүн амын хувийн жин, эрүүл мэндийн байдал, байршил, шилжилтийн байдлаар

| Эрүүл үзүүлэлтүүд | мэндийн | Гэр хороолол | | Байшин хороолол | | Нийт | |
|--|--------------|---------------|----------------|-----------------|----------------|---------------|----------------|
| | | Шилжигч | Шилжигч бус | Шилжигч | Шилжигч бус | Шилжигч | Шилжигч бус |
| Архаг хууч өвчтэй эсэх | | | | | | | |
| Өвчингүй | 85.0 | 82.6 | 90.6 | 82.9 | 86.1 | 82.8 | |
| Өвчтэй | 15.0 | 17.4 | 9.4 | 17.1 | 13.9 | 17.2 | |
| Согогтой эсэх | | | | | | | |
| Тийм | 4.8 | 6.6 | 5.0 | 4.1 | 4.8 | 5.5 | |
| Үгүй | 95.2 | 93.4 | 95.0 | 95.9 | 95.2 | 94.5 | |
| ЭМД-тай эсэх | | | | | | | |
| Байгаа | 63.3 | 70.7 | 73.1 | 82.6 | 65.2 | 76.1 | |
| Байхгүй | 35.6 | 28.1 | 24.1 | 15.2 | 33.3 | 22.3 | |
| Мэдэхгүй | 1.1 | 1.2 | 2.8 | 2.2 | 1.5 | 1.6 | |
| Бүгд 15-64 насын нийт хүн амын тоо | 100.0 547 | 100.0 2213 | 100.0 141 | 100.0 1811 | 100.0 688 | 100.0 4024 | |

Шилжигчдийн гуравны нэг нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй бөгөөд хамрагдаагүй байдал гэр хорооллын шилжигч хүн амын (35.6 хувь) хувьд байшин хороолынхоос (24.1 хувь) илүү өндөр байна.


Өгүүлэх 9. 15-64 насын, эрүүл мэндийн даатгалгүй хүн амын хувийн жин, даатгалд хамрагдаагүй шалтгаан, байршил, шилжилтийн байдлаар

| ЭМД-д шалтгаан | хамрагдаагүй | Гэр хороолол | | Байшин хороолол | | Нийт | |
|---|--------------|--------------|----------------|-----------------|----------------|--------------|----------------|
| | | Шилжигч | Шилжигч бус | Шилжигч | Шилжигч бус | Шилжигч | Шилжигч бус |
| Ажилгүй | 13.3 | 31.1 | 11.8 | 22.5 | 13.1 | 28.4 | |
| Мөнгөний боломжгүй | 38.5 | 36.4 | 35.3 | 27.5 | 38.0 | 33.7 | |
| Бүртгэлгүй | 27.2 | 7.9 | 26.5 | 8.7 | 27.1 | 8.1 | |
| Надад хэрэггүй | 8.7 | 12.6 | 17.6 | 19.6 | 10.0 | 14.7 | |
| Яж хамрагдахаа мэддэггүй | 4.1 | 2.7 | 2.9 | 3.6 | 3.9 | 3.0 | |
| Өөрийн хариуцлагагүйгээс | 3.1 | 7.6 | 2.9 | 14.1 | 3.1 | 9.6 | |
| Хувийн секторт ажилладаг | 3.1 | 0.8 | 2.9 | 0.7 | 3.1 | 0.8 | |
| Мэдэхгүй | 2.1 | 1.0 | - | 3.3 | 1.7 | 1.7 | |
| Бүгд 15-64 насын, эрүүл мэндийн даатгалгүй хүн амын тоо | 100.0 195 | 100.0 621 | 100.0 34 | 100.0 276 | 100.0 229 | 100.0 897 | |

Эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй хүмүүсээс шалтгааныг (Хүснэгт 9) тодруулбал, шилжигч хүн амын мөнгөний боломжгүй (38.0 хувь), бүртгүүлээгүй (27.1), ажилгүй (13.1) гэсэн шалтгаанууд давамгайлж байхад шилжигч бус хүн амын хувьд мөнгөгүй (33.7 хувь), ажилгүй (28.4 хувь), ажил хайх шаардлагагүй


(14.7 хувь) гэсэн шалтгаанууд илүү хувийг эзэлж байна. Ажилгүй учраас даатгалд хамрагдаагүй гэсэн шалтгаан гэр хорооллын шилжигч бус хүн амын дунд хамгийн өндөр байв.

5. Шилжин ирсэн шалтгаан



Судалгаанд хамрагдагдсан шилжигчдийн 72.1 хувь нь Улаанбаатар хотод 1-4 жилийн өмнө ирж суурьшжээ (Зураг 2).

Шилжин ирэгсдийн 30.7 хувь нь Төвийн бүсээс, 27.3 хувь нь Баруун бүсээс, 26.9 хувь нь Хангайн бүсээс, 12.8 хувь нь Зүүн бүсээс тус тус ирсэн байна (Хүснэгт 10). Шилжигчдийг аймгаар авч үзэхэд хамгийн өндөр хувийг Төв (12.8 хувь), Увс (9.2 хувь) аймгуудаас ирэгсэд эзэлж байна (Зураг 3).



Байршилаар үзвэл шилжигчдийн тал орчим хувь нь сумын төвөөс иржээ. Гадаадаас ирсэн хүмүүс бараг бүгд байшин хороололд амьдарч байгаа нь нэлээд

сонирхол татаж байна. Үүнийг гадаад шилжих хөдөлгөөн нэг талаас тухайн өрхийн амьжиргаанд нэмэр болдог, нөгөө талаас гадаад шилжих хөдөлгөөнд байшин хороололд амьдардаг, амьжиргааны боломжийн нөхцөлтэй хүмүүс илүү оролцдог гэж тайлбарлаж болох юм.

Өгүүлэлт 10. Шилжин ирэгчдийн хувийн жин, шилжин ирэхээс өмнө амьдарч байсан байршил, шилжилтийн шалтгаан, байршилаар

| Үзүүлэлтүүд | Байршил | | Нийт |
|---|-----------------|-----------------|-------|
| | Гэр хороолол | Байшин хороолол | |
| Шилжин ирэхээс өмнө амьдарч байсан газар | | | |
| Хангайн бүс | 27.2 | 25.5 | 26.9 |
| Баруун бүс | 28.7 | 22.0 | 27.3 |
| Төвийн бүс | 31.4 | 27.7 | 30.7 |
| Зүүн бүс | 12.4 | 14.2 | 12.8 |
| Гадаад | 0.2 | 10.6 | 2.3 |
| Шилжин ирэхээс өмнө амьдарч байсан байршил | | | |
| Аймгийн төв | 30.5 | 46.1 | 33.7 |
| Тосгон | 2.6 | 2.8 | 2.6 |
| Сумын төв | 50.6 | 35.5 | 47.5 |
| Хөдөө | 16.1 | 6.4 | 14.1 |
| Гадаад | 0.2 | 9.2 | 2.0 |
| Шилжилтийн шалтгаан | | | |
| Эдийн засгийн | 39.9 | 29.8 | 37.8 |
| Эдийн засгийн бус | 38.2 | 61.7 | 43.0 |
| Аль аль нь | 21.9 | 8.5 | 19.2 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| Тоо | 547 | 141 | 688 |

Бид шилжих хөдөлгөөний гол зорилго нь эдийн засгийнх байх болов уу гэж таамаглаж байсан боловч шилжигчдийн 37.8 хувь л ийм хариултыг өгсөн юм. Харин шилжигчдийн дийлэнх буюу 43 хувь нь эдийн засгийн бус зорилгоор хотод шилжин иржээ. Гэр хороололд шилжин ирсэн хүмүүсийн хувьд эдийн засгийн зорилгоор шилжих хөдөлгөөнд оролцсон хувь бусдаас арай илүү байв.

“Хотод ирж байгаа хүмүүс нь хэдэн малаа барсан, амьдрах аргагүй болсон хүмүүс энд хүнд зарагдаж байж хэдэн төгрөг ольё гэж, харин зарим нэг сүйхээтэй нь соёл боловсролын үйлчилгээнд ойртох гэж ирж байна”

(Д, эмэгтэй, нас 53, Хорооны засаг дарга, СХД)

Шилжигчдээс шилжих хөдөлгөөнд оролцох болсон гол шалтгааныг асуухад давхардсан тоогоор хариулагчдын 41.4 хувь нь ажил эрхлэхээр, 38.4 хувь нь амьжиргаагаа дээшлүүлэхээр, 36.9 хувь нь суралцахаар, 27.9 хувь нь зах зээлд ойртохоор хот, суурин бараадсан байна (Хүснэгт 11).

Шилжих хөдөлгөөний татах түлхэх хүчний онолын үүдиээс авч үзэхэд, нийслэл болон хөдөө орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн ялгавартай байдал нь хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний гол татах хүчин зүйлс болж байна.

ӴԾӢӦ 11. Шилжин ирэгчдийн хувийн жин, шилжин ирсэн зорилго, Улаанбаатарт бүртгэлтэй эсэх, байршилаар

| Сонгосон үзүүлэлтүүд | Байршил | | Нийт |
|---|--------------|-----------------|-------|
| | Гэр хороолол | Байшин хороолол | |
| Шилжин ирсэн зорилго* | | | |
| Бизнес эрхлэх | 3.3 | 3.5 | 3.3 |
| Ажил эрхлэх | 42.2 | 38.3 | 41.4 |
| Амьжиргаагаа дээшлүүлэх | 42.8 | 21.3 | 38.4 |
| Зах зээлд ойртох | 30.5 | 17.7 | 27.9 |
| Суралцах | 35.8 | 41.1 | 36.9 |
| Байгаль/цаг уурын нөхцлийг сайжруулах | 2.4 | 0.0 | 1.9 |
| Нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах | 8.4 | 10.6 | 8.9 |
| Хамаатан садантайгаа ойртох | 22.7 | 27.7 | 23.7 |
| Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах | 14.6 | 3.5 | 12.4 |
| Бусад | 5.7 | 2.8 | 3.8 |
| Шилжин ирсэн зорилгоо биелүүлж чадсан эсэх | | | |
| Тийм | 66.4 | 87.9 | 70.8 |
| Үгүй | 33.6 | 12.1 | 29.2 |
| Шилжин ирэлтээ бүртгүүлсэн эсэх (Улаанбаатарт) | | | |
| Тийм | 47.0 | 52.5 | 48.1 |
| Үгүй | 53.0 | 47.5 | 51.9 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| Тоо | 547 | 141 | 688 |

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Шалтгааныг гэр, байшин хороололд амьдарч байгаагаар ангилж үзэхэд шилжин ирсэн шалтгаан хоорондоо бага зэрэг ялгаатай байлаа. Тухайлбал, гэр хороололд амьдардаг шилжин ирэгсдийн хувьд амьжиргаагаа дээшлүүлэх (42.8 хувь), ажил эрхлэх (42.2 хувь) гэсэн шалтгаан голлож байлаа. Байшин хороололд амьдардаг шилжин ирэгсдийн хувьд суралцах (41.1 хувь), ажил эрхлэх (38.3 хувь) шалтгаанууд зонхицж байна.

Шилжин ирсэн шалтгааныг хүйсээр үзвэл давхардсан тоогоор эрэгтэйчүүдэд ажил эрхлэх (45.7 хувь), амьжиргаагаа дээшлүүлэх (43.5 хувь) гэсэн шалтгаан, харин эмэгтэйчүүдэд суралцах (40.7 хувь), ажил эрхлэх (37.7 хувь) гэсэн шалтгаан зонхицж байлаа. Мөн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол шилжин ирсэн зорилгоо илүү биелүүлсэн байна.

Нийслэлд шилжин ирэгсдийн 71 хувь нь шилжин ирсэн зорилгоо биелүүлсэн гэж үнэлжээ. Байшин хороололд амьдарч буй шилжин ирэгчдийн зорилгодоо хүрсэн байдал (87.9 хувь) гэр хороололд амьдарч буй шилжигчдээс 20 орчим пунктээр илүү байна. Өөрөөр хэлбэл, байшин хороололд амьдарч буй шилжигчид шилжилтдээ илүү сэтгэл хангалуун амьдарч байна.

Шилжигчдийн тал хүрэхгүй (48.1) хувь нь хот руу нүүж ирэхдээ орон нутгаасаа шилжүүлэг, зөвшөөрөл авчээ.

Одийн 12. Шилжин ирэгчдийн хувийн жин, шилжин ирсэн зорилго, Улаанбаатарт бүртгэлтэй эсэх, хүйсээр

| Сонгосон үзүүлэлтүүд | Хүйс | | Нийт |
|--|---------|---------|-------|
| | Эрэгтэй | Эмэгтэй | |
| Шилжин ирсэн зорилго* | | | |
| Бизнес эрхлэх | 3.2 | 3.5 | 3.3 |
| Ажил эрхлэх | 45.7 | 37.7 | 41.4 |
| Амьжиргаагаа дээшлүүлэх | 43.5 | 34.0 | 38.4 |
| Зах зээлд ойртох | 31.2 | 25.1 | 27.9 |
| Суралцах | 32.5 | 40.7 | 36.9 |
| Байгаль/цаг уурын нөхцлийг сайжруулах | 1.6 | 2.2 | 1.9 |
| Нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах | 9.1 | 8.6 | 8.9 |
| Хамаатан садантайгаа ойртох | 24.3 | 23.2 | 23.7 |
| Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах | 12.6 | 12.1 | 12.4 |
| Бусад | 3.4 | 4.0 | 3.8 |
| Шилжин ирсэн зорилгоо биелүүлж чадсан эсэх | | | |
| Тийм | 68.8 | 72.5 | 70.8 |
| Үгүй | 31.2 | 27.5 | 29.2 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| Тоо | 547 | 141 | 688 |

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

Сонирхолтой нь шилжих хөдөлгөөний шалтгаан жил ирэх тутам өөрчлөгдсөн нь харагдаж байна. Ялангуяа суралцах, нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах гэсэн шалтгаанаар шилжин ирэгчдийн хувийн жин буурч эдийн засгийн болох ажил эрхлэх, зах зээлд ойртох болон амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн шалтгаан зонхилох болсон байна. Энэ нь шилжих хөдөлгөөн цаашид ч өндөр хэвээр хадгалагдах болов уу гэсэн таамаглалыг төрүүлж байгаа юм.

Одийн 13. Шилжин ирэгчдийн хувийн жин, шилжин ирсэн хугацаагаар,

| Сонгосон үзүүлэлтүүд | Хугацаа | | |
|---------------------------------------|--------------|---------|---------|
| | 1 хүртэл жил | 1-2 жил | 3-4 жил |
| Шилжин ирсэн зорилго* | | | |
| Бизнес эрхлэх | 4.2 | 1.9 | 3.9 |
| Ажил эрхлэх | 47.9 | 43.4 | 35.6 |
| Амьжиргаагаа дээшлүүлэх | 46.4 | 31.1 | 38.4 |
| Зах зээлд ойртох | 35.9 | 25.0 | 24.6 |
| Суралцах | 31.3 | 38.2 | 39.8 |
| Байгаль/цаг уурын нөхцлийг сайжруулах | 0.5 | 1.9 | 2.8 |
| Нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах | 3.1 | 9.9 | 12.0 |
| Хамаатан садантайгаа ойртох | 26.0 | 29.7 | 17.6 |
| Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах | 14.6 | 15.6 | 8.5 |
| Бусад | 2.5 | 4.7 | 7.0 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| Тоо | 547 | 141 | 688 |

Тэмдэглэл: * - Давхардсан тоогоор

6. Оршин сууж буй газрын бүртгэл


Шилжин ирэгсдэд тулгарч буй нэг гол бэрхшээл нь оршин суугаа газартаа бүртгүүлж чадахгүй байгаа явдал юм. Тухайн оршин суугаа газраа бүртгүүлж чадаагүйгээс болж нийгмийн үйлчилгээг хүртэж чадахгүйд хүрч буйг бүлгийн ярилцлагаас харагдаж байна.

“Эгч нь амьдралаа дээшилүүлэх, хэдэн хуухдээ сайн сурч, боловсролтой болгохын тулд бор зүрхээрээ зүтгээд ирсэн. Түүнээс би энд түшиг тулах, ах дүү байхгүй, таних хүн байхгүй. Гэтэл шилжүүлэг байхгүй, хороондоо бүртгүүлээгүй гээд сургуульд хүүхэд авдаггүй”

*(Ж, эмэгтэй, нас 43, ажилгүй, шилжин ирсэн бүртгэлгүй,
СХД)*

Шилжигчдийн 52 хувь буюу 357 хүн шилжин ирэлтээ бүртгүүлж, Улаанбаатар хотод амьдрах зөвшөөрлөө аваагүй байна. Бүртгүүлээгүй хүмүүсийн 47.3 хувь нь эрэгтэй, 52.7 хувь нь эмэгтэй, 51.3 хувь нь ганц бие хүмүүс байв. Эдгээр хүмүүсийн 63.9 хувь нь ажил эрхлээгүй байгаагаас гадна дийлэнх (81.2 хувь) нь гэр хороололд амьдарч байна.

Дүүргээр үзвэл Сонгинохайрхан дүүрэгт бүртгэлгүй шилжигчид хамгийн өндөр хувийг эзэлж байна (Зураг 4).



Хүснэгт 14-т шилжин ирэгсдийн бүртгүүлээгүй шалтгааныг хүйсээр харуулав.

Хүснэгт 14. Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын хувийн жин, бүртгүүлээгүй шалтгаан, хүйсээр

| Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй шалтгаан | Хүйс | | Нийт |
|---|---------|---------|-------|
| | Эрэгтэй | Эмэгтэй | |
| Баримт бичиг байхгүй | 13.0 | 13.8 | 13.4 |
| Орон нутгийн шилжүүлэлтгүй | 22.5 | 19.7 | 21.0 |
| Санхүүгийн боломжгүй | 23.7 | 23.9 | 23.8 |
| Өөр газар руу шилжих хүсэлтэй | 0.6 | 1.1 | 0.8 |
| Бүртгүүлэх шаардлагагүй | 7.7 | 10.1 | 9.0 |
| Бүртгүүлж амжаагүй | 31.4 | 30.3 | 30.8 |
| Бусад | 1.2 | 1.1 | 1.1 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын тоо | 169 | 188 | 357 |

Улаанбаатар хотод шилжин ирээд бүртгүүлээгүй гол шалтгаан нь бүртгүүлж амжаагүй (30.8 хувь), мөнгөгүй (23.8 хувь), орон нутгийн шилжүүлэггүй (21.0 хувь) гэсэн шалтгаанууд болж байлаа. Бүртгүүлэх шаардлагагүй гэж хариулсан хариулагчид багагүй (9 хувь) хувь эзэлж байгаа ба ялангуяа, байшин хороололд шилжин ирсэн олон эмэгтэйчүүд ийм хариултыг өгчээ.

Бүртгүүлээгүй шалтгааныг байршилаар үзэхэд гэр хороололд бүртгүүлж амжаагүй (32.4 хувь), мөнгөгүй (26.2 хувь) гэсэн шалтгаан, харин байшин хороололд бүртгүүлж амжаагүй (23.9 хувь), орон нутгийн шилжүүлэггүй (28.4 хувь) гэсэн шалтгаан өндөр хувьтай байна (Хүснэгт 15).

Огийн 15. Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын хувийн жин, бүртгүүлээгүй шалтгаан, байршилаар

| Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй шалтгаан | Байршил | | Нийт |
|--|--------------|-----------------|--------------|
| | Гэр хороолол | Байшин хороолол | |
| Баримт бичиг байхгүй | 13.8 | 11.9 | 13.4 |
| Орон нутгийн шилжүүлэггүй | 19.3 | 28.4 | 21.0 |
| Санхүүгийн боломжгүй | 26.2 | 13.4 | 23.8 |
| Өөр газар руу шилжих хүсэлтэй | 0.7 | 1.5 | 0.8 |
| Бүртгүүлэх шаардлагагүй | 6.2 | 20.9 | 9.0 |
| Бүртгүүлж амжаагүй | 32.4 | 23.9 | 30.8 |
| Бусад | 1.4 | 0.0 | 1.1 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 |
| Шилжин ирэлтээ бүртгүүлээгүй хүн амын тоо | 290 | 67 | 357 |

Бүртгэл ба шилжих хөдөлгөөний зохицуулалт

Бүртгэл нь шилжих хөдөлгөөнийг зохицуулах тохиромжтой арга мөн үү? Дээр бид шилжигчдийн талаас илүү хувь нь оршин суугаа газартаа бүртгүүлээгүй байгаа гэж тэмдэглэсэн билээ. Тиймээс бүртгэл нь шилжих хөдөлгөөнийг зохицуулах тохиромжтой арга биш гэдэг нь харагдаж байна. Түүнчлэн шилжин ирэгчдийн шалтгааныг авч үзэхэд ч бүртгэл нь хүмүүсийг ирээдүйд шилжихээс урьдчилан сэргийлж чадахгүй гэж хэлж болохоор байгаа юм. Гэвч Хүснэгт 9-с харахад бүртгэлийн асуудал нь шилжигчдийн хувьд нийгмийн үйлчилгээ тухайлбал, эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжийг хязгаарлаж байна. Эрүүл мэндийн даатгалгүй шилжигчдийн (гуравны нэг нь) эрүүл мэндээ даатгуулж чадахгүй (даатгалгүй шилжигчдийн дөрөвний нэг) байгаа гол шалтгаан нь бүртгэл гэж хариулсан байв. Тиймээс бүртгэл нь хүмүүст нийгмийн халамж, үйлчилгээг ойртуулах гэсэн зорилтыг биелүүлж чадахгүй байгаагаар зогсохгүй сөрөг үр дагаварыг бий болгож байна. Бүртгэлийн үйл явцыг төлбөргүй болгож харьцангуй хөнгөвчилсөн нь оновчтой шийдвэр болж чадсаныг судалгааны дүн батлаж байна.

7. Ирээдүйн шилжилт

Ирээдүйд шилжилтийн талаар судалгаанд хамрагдагсдаас асуусан бөгөөд дүнг хүн амын амьжиргааны түвшин, байршилаар Хүснэгт 16-д харуулав.

Судалгаагаар шилжигчдийн 15 хувь нь цаашид дахин шилжих хөдөлгөөнд орно гэжээ. Харин 1.2 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна.

Амьжиргааны түвшин дээшлэх тусам өөр газар руу шилжинэ гэсэн хариултын хувь нэмэгдэж байна. Магадгүй тэдний ихэнх нь гадаад шилжих хөдөлгөөнд оролцох сонирхолтой байж болох юм. Учир нь 2000 онд явуулсан Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаагаар ирээдүйд шилжих хөдөлгөөнд оролцено гэсэн Улаанбаатар хотын шилжих хөдөлгөөнд оролцсон хүн амын тавны нэг, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амын бараг тал орчим хувь нь гадаад явна гэж хариулсан байв. Түүнчлэн шилжих хөдөлгөөний том урсгал буцах шилжилтийг үргэлж дагуулж байдаг. Тиймээс шилжигчдийн тодорхой хувь энэхүү буцах хөдөлгөөнд оролцох магадлалтай юм.

Хүснэгт 16. Судалгаанд хамрагдсан 15-64 насны хүн амын хувийн жин, ирээдүйн шилжилт, амьжиргааны түвшин, байршилаар

| Ирээдүйд шилжих хүснэгтэй эсэх | Амьжиргааны түвшин | | | | | | | | | |
|--------------------------------|--------------------|--------|-------|--------|------------------------------|--------|------------------------------|--------|------------------------|--------|
| | Нэн ядуу | | Ядуу | | Ядуу бус (бага орлоготой) | | Ядуу бус (дунд орлоготой) | | Ядуу бус (чинээлэг) | |
| | Гэр | Байшин | Гэр | Байшин | Гэр | Байшин | Гэр | Байшин | Гэр | Байшин |
| Шилжинэ | 4.5 | 3.9 | 9.5 | 11.2 | 12.0 | 10.6 | 10.8 | 15.6 | 15.8 | 20.7 |
| Шилжихгүй | 94.6 | 96.1 | 89.8 | 88.3 | 87.9 | 89.4 | 89.0 | 83.7 | 83.2 | 78.7 |
| Мэдэхгүй | 0.8 | 0.0 | 0.7 | 0.5 | 0.1 | 0.0 | 0.2 | 0.7 | 1.1 | 0.6 |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Тоо | 354 | 76 | 851 | 206 | 903 | 480 | 462 | 557 | 190 | 633 |

Ирээдүйд шилжих хөдөлгөөнд орно гэж хариулсан гэр хорооллын нэн ядуучуудын эзлэх хувийн жин ядуу бус (өндөр) хүмүүсийнхээс 4 дахин бага, ядуу бус (дунд) хүмүүсийнхээс 2 дахин бага байна. Харин байшин хорооллын ирээдүйд шилжинэ гэсэн нэн ядуу иргэдийн эзлэх хувь ядуу бус (өндөр) иргэдийнхээс 5 дахин доогуур байна. Эндээс хараад шилжих хөдөлгөөнд нэн ядуу иргэд бараг оролцогтгүй гэсэн онолын дүгнэлт манай орны нөхцөлд ч батлагдаж байна.

8. Шилжих хөдөлгөөн ба ядуурал

Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөн хотын ядууралд хэрхэн нөлөөлж буй байдлыг судлах явдал манай судалгааны нэг томоохон зорилт байв. Иймд энд шилжих хөдөлгөөн ба ядуурлын хоорондын хамаарлын талаар нэлээд дэлгэрэнгүй танилцуулах болно. Шилжигчид илүү идэвхтэй, амжилт руу тэмүүлсэн шинж чанартай байж болох талтай. Улмаар тэд эдийн засгийн үйл ажиллагаанд илүү идэвхтэй оролцож, албан бус секторыг ч өргөжүүлэхэд нөлөө үзүүлж болох юм. Энэ нь эргээд шилжигч бус хүн амын хувьд орлого олох, ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд хүргэдэг туршилага улс орнуудад ажиглагдсан байдаг. Үүний зэрэгцээ шилжигчид нь нийгмийн үйлчилгээний салбарт илүү дарамтыг үзүүлж, ядуу шилжигч бус иргэдийг улам ядууруулахад хүргэж ч болно. Ийнхүү олон хувилбарыг таамаглан олж болох юм. Эдгээр хувилбарын чухам аль нь илрэх магадлал өндөр байхыг үнэндээ таахын аргагүй. Гэхдээ энэхүү судалгааны хүрээнд шилжих хөдөлгөөн болон ядуурлын хооронд ямар нэгэн хамаарал байгаа эсэхийг хэмжин тодорхойлж болох юм.

Өмнө хэлсэнчлэн шилжигчид (37 хувь) шилжигч бус хүмүүсээс (31 хувь) илүү ядуу байна. Гэхдээ энэ ялгаа нь шилжих хөдөлгөөн ядууралд нөлөө үзүүлж байна гэдгийг бататгах болов уу? Энэ асуултанд хариулах зорилгоор хоёр ложистик регрессийн шинжилгээг хийсэн юм. Загвар А-д шилжих хөдөлгөөнийг цорын ганц үл хамаарах хувьсагч болгон авсан. Загвар Б-д ядуу байх эсэхэд нөлөөлж болох бусад үл хамаарах хүчин зүйлсийг оруулан тооцсон юм. Ийнхүү магадлалын харьцааг Хүснэгт 17-д харуулав.

Хүснэгт 17. Ядуу өрхийн магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр

| Сонгосон үзүүлэлт | Загвар А | | Загвар Б | | Өрхийн тоо |
|--|-------------------|----------------|-------------------|----------------|------------|
| | Магадлалт харьцаа | Стандарт алдаа | Магадлалт харьцаа | Стандарт алдаа | |
| Шилжих хөдөлгөөнд оролцсон байдал | | | | | |
| <i>Øёөжөөж аой</i> | - | - | - | - | 1324 |
| Шилжигч | 1.434* | 0.258 | 1.382 | 0.272 | 176 |
| Дүүрэг | | | | | |
| Баянзүрх | | - | - | - | 200 |
| Налайх | | 0.960 | 0.306 | 100 | |
| Сүхбаатар | | 0.590* | 0.134 | 350 | |
| Сонгинохайрхан | | 0.772 | 0.159 | 500 | |
| Хан-Уул | | 0.521* | 0.172 | 100 | |
| Чингэлтэй | | 0.752 | 0.174 | 250 | |
| Өрхийн тэргүүлэгчийн хүйс | | | | | |
| Эрэгтэй | | - | - | - | 895 |
| Эмэгтэй | | 1.248 | 0.271 | 155 | |
| | | 0.421* | 0.145 | 101 | |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | | 1.003 | 0.992 | 0.499 | |
| Өрхийн тэргүүлэгчийн гэрлэлтийн байдал | | | | | |
| Баталгаатай гэр бүл | | - | - | - | 895 |
| Баталгаагүй гэр бүл | | 1.248 | 0.271 | 155 | |
| Огт гэрлээгүй | | 0.421* | 0.145 | 101 | |
| Тусгаарласан | | 0.992 | 0.499 | 33 | |
| Салсан | | 1.236 | 0.431 | 64 | |
| Бэлэвсэн | | 1.347 | 0.361 | 252 | |
| Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин | | | | | |
| Бүрэн дундаас дээш | | - | - | - | 675 |
| Бүрэн дунд | | 1.869*** | 0.323 | 403 | |
| Бүрэн бус дунд | | 3.797*** | 0.672 | 272 | |
| Боловсролгүй/бага боловсролтой | | 3.666*** | 0.831 | 150 | |
| Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс | | | | | |
| Халх | | - | - | - | 1313 |
| Казак | | 0.944 | 0.412 | 35 | |
| Дөрвөд | | 0.551 | 0.257 | 43 | |
| Вуриад | | 1.219 | 0.564 | 30 | |
| Баяд | | 1.323 | 0.206 | 37 | |
| Бусад | | 1.168 | 0.424 | 42 | |
| Тоо | | | | | 1500 |
| -2 log likelihood (утга) өөрчлөлт | -797,201* | -736,874*** | | | |

Тэмдэглэл: * $p \leq 0.05$ статистик ач холбогдолын түвшинд сүл хамааралтай
*** $p \leq 0.001$ статистик ач холбогдолын түвшинд хүчтэй хамааралтай

Магадлалын харьцаа гэж юу вэ? Жишээ нь, шилжигч өрхийн хувьд ядуу байх магадлал 1.3 дахин өндөр байна (Загвар Б). Налайх дүүрэгт дурын өрхийн үүдийг тогшиход тэр өрх ядуу байх магадлал Баянзүрх дүүрэгтэй харьцуулахад

бага (Баянзүрх дүүргийн ядуу өрх бүрт Налайх дүүргийн 0.96 ядуу өрх ногдоно) байх юм.

Хүснэгт 17-д зураас тавьсан нүд харьцуулах бүлгийг илэрхийлнэ. Энэ харьцаа нэгээс бага байвал урвуу харин нэгээс их байвал эерэг хамааралтай байгааг илтгэнэ. Харин зураасаар тэмдэглэсэн нүд байхгүй хувьсагчийн хувь үр дүнг дараах байдлаар тайлбарлана. Тухайлбал, өрхийн тэргүүлэгчийн насны магадлалын харьцаа 0.992 байна. Өрхийн тэргүүний нас нэгээр нэмэгдэх тусам ядуу өрхөд багтах магадлал 0.992-аар буурна.

Одоор (*) статистик ач холбогдолтой хамаарлыг тэмдэглэсэн юм. Од байхгүй байгаа нь тухайн хүчин зүйл ядууралтай хамааралтай байх нь Улаанбаатарын хүн амын хувьд магадлалгүй байгааг илэрхийлнэ.

Загвар А нь ядуурлын түвшин өндөр байгаа шилжигчдэд үндэслэн шилжих хөдөлгөөн ба ядуурлын хоорондын хамаарлыг илэрхийлэв. Гэвч боловсролын үзүүлэлтийг хяналтын хувьсагч болгоход өөр үр дүн гарч байна (Загвар Б). Өөрөөр хэлбэл, шилжин ирэгчид нь ядуу биш харин тэдний боловсролын түвшин нь муу байна гэсэн үг юм. Загвар Б-д шинжилсэн хүчин зүйлсээс өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин, ядуурал хоёрын хоорондын хамаарал статистик ач холбогдолтой байгааг харж болно. Тухайлбал, бүрэн дунд боловсролтой тэргүүлэгчтэй өрхийн ядуу байх магадлал техник, мэргэжлийн болон дээд боловсролтой тэргүүлэгчтэй өрхүүдтэй харьцуулахад 1.9 дахин өндөр байна. Цаашилбал, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдийн өрхүүдийн ядуу байх магадлал бага байна.

Өрхийн шилжилтийн байдал ядууралд статистик ач холбогдлын түвшинд нөлөө үзүүлэхгүй байна. Тэтвэл яагаад шилжигчид илүү ядуу байна вэ? Яагаад гэвэл тэд шилжигч учраас бус харин тэдний боловсролын түвшин доогуур байгаа учраас ядуу байна (Хүснэгт 9). Өөрөөр хэлбэл, энэ нь шилжигчдийг гадуурхах асуудалтай холбоогүй юм.

Шилжигчид болон шилжигч бус хүмүүс аль алинд нь ижил боломж байдаг боловч шилжин ирэгчдийн чадавхи сул байна.

Шилжих хөдөлгөөн ба нийгмийн эмзэг бүлэг

Уламжлалт ядуурлын үзүүлэлт болох орлого/хэрэглээний хувьд бус нийгмийн эмзэг бүлгийнхний хувьд дүр зураг арай өөр байгаа нь сонирхол татаж байна. Нийгмийн эмзэг бүлэг гэдэгт хэрэглээний ядуурал, хүртээмжийн ядуурал, болон нийгмийн оролцооны ядуурлын дор хаяж хоёр нь давхцаж байгаа, мөн хэрэглээний хувьд нэн ядуу байгаа хүмүүсийг хамруулж авч үзсэн юм.

Хэдийгээр өрхийн шилжилтийн статус өрхийн ядуу байхыг тодорхойлох хүчин зүйл биш байсан хэдий ч шилжих хөдөлгөөнд оролцсон эсэх нь нийгмийн эмзэг бүлэгт хамаарах эсэхэд чухал нөлөө үзүүлж байгааг судалгааны үр дүн харуулж байна. Өөрөөр хэлбэл, шилжигчдийн хувьд орлого бага байх (зардалд үндэслэн тооцсоор) асуудлаасаа илүү хүртээмжийн болон нийгмийн оролцооны ядуурлын асуудлууд (бүртгэлгүйн улмаас эрүүл мэндийн даатгалд хамрагдахгүй байх, илүү ядуу нөхцөлд байх гэх мэт) илүү хурц илэрч байдаг гэж дүгнэж болохоор байна.

Хүснэгт 18. Нийгмийн эмзэг өрхийн магадлалын харьцаа, сонгосон үзүүлэлтээр

| Сонгосон үзүүлэлт | Загвар А | | Загвар Б | | Өрхийн тоо |
|--|-------------------|----------------|-------------------|----------------|------------|
| | Магадлалт харьцаа | Стандарт алдаа | Магадлалт харьцаа | Стандарт алдаа | |
| <i>Шилжих хөдөлгөөнд оролцсон байдал</i> | | | | | |
| <i>Ø ёёөхөө áóñ</i> | - | - | - | - | 1324 |
| Шилжигч | 2.371*** | 0.173 | 2.039*** | 0.194 | 176 |
| <i>Дүүрэг</i> | | | | | |
| Баянзүрх | - | - | - | - | 200 |
| Налайх | 0.632 | 0.336 | 0.336 | 0.336 | 100 |
| Сүхбаатар | 0.358*** | 0.241 | 0.241 | 0.241 | 350 |
| Сонгинохайрхан | 0.564*** | 0.210 | 0.210 | 0.210 | 500 |
| Хан-Уул | 0.259*** | 0.376 | 0.376 | 0.376 | 100 |
| Чингэлтэй | 0.524** | 0.241 | 0.241 | 0.241 | 250 |
| <i>Өрхийн тэргүүлэгчийн хүйс</i> | | | | | |
| Эрэгтэй | - | - | - | - | 1144 |
| Эмэгтэй | 0.889 | 0.225 | 0.225 | 0.225 | 356 |
| Өрхийн тэргүүлэгчийн нас | 0.986* | 0.006 | 0.006 | 0.006 | 1500 |
| <i>Өрхийн тэргүүлэгчийн гэрлэлтийн байдал</i> | | | | | |
| Баталгаатай гэр бүл | - | - | - | - | 895 |
| Баталгаагүй гэр бүл | 0.573 | 0.321 | 0.321 | 0.321 | 155 |
| Огт гэрлээгүй | 1.032 | 0.232 | 0.232 | 0.232 | 101 |
| Тусгаарласан | 1.626 | 0.530 | 0.530 | 0.530 | 33 |
| Салсан | 2.201* | 0.354 | 0.354 | 0.354 | 64 |
| Бэлэвсэн | 1.213 | 0.293 | 0.293 | 0.293 | 252 |
| <i>Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин</i> | | | | | |
| Бүрэн дундаас дээш | - | - | - | - | 675 |
| Бүрэн дунд | 2.797*** | 0.187 | 0.187 | 0.187 | 150 |
| Бүрэн бус дунд | 5.295*** | 0.193 | 0.193 | 0.193 | 272 |
| Боловсролгүй/бага боловсролтой | 5.873*** | 0.247 | 0.247 | 0.247 | 403 |
| <i>Өрхийн тэргүүлэгчийн яс үндэс</i> | | | | | |
| Халх | - | - | - | - | 1313 |
| Казак | 2.918* | 0.432 | 0.432 | 0.432 | 35 |
| Дөрвөд | 1.016 | 0.430 | 0.430 | 0.430 | 43 |
| Вуриад | 0.672 | 0.594 | 0.594 | 0.594 | 30 |
| Баяд | 1.298 | 0.455 | 0.455 | 0.455 | 37 |
| Бусад | 1.294 | 0.379 | 0.379 | 0.379 | 42 |
| Тоо | | | | | 1500 |
| -2 log likelihood (утга) өөрчлөлт | 1502.584* | | 1340.297* | | |
| | ** | | ** | | |

Тэмдэглэл: * $p \leq 0.05$ статистик ач холбогдолын түвшинд сүл хамааралтай

*** $p \leq 0.001$ статистик ач холбогдолын түвшинд хүчтэй хамааралтай

Дүгнэлт, зөвлөмж

Хотод шилжин ирэгсдийн дийлэнх нь гэр хороололд амьдардаг бөгөөд тэдний ихэнх нь бүрэн дунд ба түүнээс доогуур боловсролын түвшинтэй байна.

Шилжигчдийн ихээхэн хувь нь Төв болон Баруун бүсээс ажил эрхлэхээр, суралцахаар, зах зээлд ойртох гэх мэт эдийн засгийн шалтгаанаар шилжин иржээ.

Шилжих хөдөлгөөний шалтгаан өөрчлөгдөж ирсэн байна. Ялангуяа суралцах, нийгэм, соёлын хэрэгцээгээ хангах гэсэн шалтгаанаар шилжин ирэгчдийн хувийн жин буурч, эдийн засгийн болох ажил эрхлэх, зах зээлд ойртох болон амьжиргаагаа дээшилүүлэх гэсэн шалтгаан зонхилох болсон байна. Энэ нь шилжих хөдөлгөөн цаашид ч өндөр хэвээр хадгалагдах болов уу гэсэн сэтгэгдлийг төрүүлж байгаа юм.

Шилжигчдийн дийлэнх (71 хувь) нь өөрсдийн зорилгоо биелүүлж чадсан байна.

Шилжигчдийн талаас илүү хувь (52 хувь) нь нийслэлд шилжих хөдөлгөөний бүртгэлээ хийлгээгүй байв. Бүртгэл нь хүмүүсийг ирээдүйд шилжихээс урьдчилан сэргийлж чадахгүй гэж хэлж болохоор байгаа юм. Гэвч бүртгэлийн асуудал нь шилжигчдийн хувьд нийгмийн үйлчилгээ хүртэх боломжийг хязгаарлаж байна. Тиймээс бүртгэл нь хүмүүст нийгмийн халамж, үйлчилгээг ойртуулах гэсэн зорилгыг биелүүлж чадахгүй байна. Бүртгэлийн үйл явцыг төлбөргүй болгож харьцангуй хөнгөвчилсөн нь оновчтой шийдвэр болж чадсаныг судалгааны дүн баталж байна.

Шилжигчид илүү ядуу байгаа бөгөөд хотын ядуурал нэмэгдэхэд тэд нэрмээс болж байна. Гэхдээ шилжилтийн статус ядуурлыг тодорхойлохгүй гэдэг нь шинжилгээний дүнгээс харагдаж байгаа юм. Тэд шилжигч учраас бус харин боловсролын түвшин доогуур учраас ядуу байна. Шилжигчид болон шилжигч бус хүмүүсийн аль алинд нь ижил боломж байдаг боловч шилжин ирэгсдийн чадавхи илүү сул байгаа юм.

Шилжих хөдөлгөөнд оролцох гол шалтгаануудад амьжиргаагаа дээшилүүлэх, зах зээлд ойртох, ажил эрхлэх зэргийг нэрлэсэн нь шилжих хөдөлгөөнийг сааруулахад уугуул нутгуудийн нөхцлийг сайжруулах оновчтой арга болох юм. Хэдийгээр суралцах шалтгаанаар ирэгсдийн хувь буурсан хандлага ажиглагдсан боловч энэ нь шилжих гол шалтгаануудын нэг болж байгаа учраас боловсролын асуудалд анхаарах нь чухал байна.

Судалгаанаас шилжих хөдөлгөөнтэй холбоотой дараах бодлогын зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

- Хүний халдашгүй дархан эрхийг хүндэтгэх, нийслэлд шилжин ирэгчдийн амьдрах таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй.
- Хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулахын тулд хөдөө, орон нутгийн амьдралын нөхцлийг сайжруулах, амьдрах сонирхлыг татах хөдөөгийн хөгжлийн нарийн төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. ПСА, 2002. Улаанбаатар хотын гэр хорооллын орчин ахуй. Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Улаанбаатар Монгол
2. НХХЯ, ХАССТ, НУБХАС, 2001. Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа 2000. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын сургалт, судалгааны төв, НУБ-ын хүн амын сан, Улаанбаатар, Монгол
3. УСГ, 1999. Хүн амын амьжиргааны түвшний судалгаа 1998. Үндэсний статистикийн газар, НУБХХ, Улаанбаатар, Монгол
4. УСГ, 2001. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллого: Үндсэн үр дүн. Үндэсний статистикийн газар, Улаанбаатар, Монгол